




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт




ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **2.1%**,
Инфляци: 2020 онд: **6.6%**,
Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>


ДНБ-ий өсөлт: 2020 онд: **-1%**
Инфляци: 2020 онд: **5.6%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.2%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 12-р сарын байдлаар (4539) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 12.8 хувиар буурсан бол, зарлага 22 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4539 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 623 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 0.45 төгрөгөөр буурсан байна.

Арванхоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 122 төгрөг буюу 4.5 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.45 төгрөг буюу -0.02 хувиар буурч, өмнөх улирлаас 0.16 хувиар буурч 2849.55 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 3.87 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 4 хувиар өсч, оны эхнээс 11 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 2.3%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 12-р сарын байдлаар өмнөх сараас 0.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар, оны эхнээс 2.3 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн ч тээврийн бүлгийн үнэ 5.2 хувиар буурсан байна.




Гадаад худалдааны тэнцэл 2282 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны арванхоёрдугаар сард нийт барааны эргэлт 12870 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 2.8, импорт өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 2282 сая ам.долларын ашигтай гарав.



12-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ



Эх сурвалж: www.mongolbank.mn

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12-р сард өмнөх сараас 1.2 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 4.9 хувиар буурч 17.2 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 2010 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.2 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 10.1 хувиар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11.3% байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 90.0 (7.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 445.4 (54.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.4 хувийг эзлэв. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 12 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 3.1 (0.2%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оноос 184.5 (10.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

САРЫН ОНЦЛОХ

ИПОТЕКИЙН 41 ГАРУЙ МЯНГАН ЗЭЭЛДЭГЧИЙН ТӨЛӨЛТИЙГ ХОЙШЛУУЛАВ

- Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамрагдагсдын зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан. Энэхүү шийдвэр дахин хэрэгжиж эхэлснээр 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 2.4 их наяд төгрөгийн 44 907 зээлдэгчийн хүсэлтийг банкууд хүлээн авчээ. Эдгээр хүсэлтээс дээрх өдрийн байдлаар нийт хүсэлтийн 92 орчим хувь буюу 2.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 41 533 зээлдэгчийн хүсэлтийг шийдвэрлэж эргэн төлөлтийг хойшлуулав.

НҮҮРС, ЗЭСИЙН ОРЛОГО БУУРЧ, АЛТ, ТӨМРИЙ ХҮДРИЙН ЭКСПОРТ НЭМЭГДЭВ.

- Манай улсын ДНБ энэ оны эхний улиралд 10.7 хувиар буурав. Уул уурхайн олборлолт 29.5, бүтээгдэхүүний цэвэр татвар 7.9, үйлчилгээний салбар 6.8 хувиар буурсан нь эдийн засгийн гол үзүүлэлт болох ДНБ-нд нөлөөлсөн. ХАА-н салбар 14 хувиар, аж үйлдвэр, барилгын салбар 6.4 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Эдийн засгийн өсөлт оны эхний хагас буюу II улиралд өмнөх онтой харьцуулахад 9.7, III улиралд 7.3 хувиар буурсан. Эдийн засагт голлон нөлөөлдөг экспорт, импортыг тодорхойлдог гадаад худалдааны нөхцөл байдлыг энэ оны 11 дүгээр сарын байдлаар танилцуулвал экспорт 6.8 тэрбум ам.доллар импорт 4.8 тэрбум ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 1.9 тэрбум ам.долларын ашигтай гараад байна. Ийнхүү ашигтай гарахад алтны экспорт 4.7 хувь, дахин нэмэгдэж 1.6 тэрбум ам.долларт хүрч, импортын хэмжээ 12.5 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 12-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 12-р сар 2020 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn